



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/80

Хэрлэн сум

Төсөл арга хэмжээний гэрээ байгуулах  
болон худалдан авах ажиллагаа зохион  
байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.6, 8.7, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 18 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд болон Хэнтий аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулах гэрээ”-ний 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтын дагуу Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад заасан IX.1.131 дугаартай “Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээ (Хэнтий, Баян-Адарга, Баян-Овоо, Баянхутаг, Дадал, Дэлгэрхаан, Мөрөн, Норовлин, Цэнхэрмандал сум, Батноров сум, Бэрх тосгон)” төсөл арга хэмжээний гэрээ байгуулах болон худалдан авах ажиллагааг зохион байгуулсугай.

2.Төсөл арга хэмжээнүүдийн гэрээ байгуулах болон худалдан авах ажиллагааны дүн, санхүүжих дүнг хавсралтаар баталсугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын  
2023 оны 06 дугаар сарын 08-ний  
18 дугаар захирамжийн хавсралт

2023 онд төсөвт өртөг нэмэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Хуулийн дугаар	Төслийн нэр, хүчин чадал	Эхлэх он	Дуусах он	Анх батлагдсан төсөвт өртөг	2023 онд төсөвт өртөг нэмэгдсэн дүн	Үнийн өсөлтийн дүн	Нийт төсөвт өртөг	Батлагдсан төсвийн дагуу байгуулсан гэрээний дүн	Өмнө онуудад олгосон санхүүжилт	2023 онд гэрээ байгуулах болон худалдан авах арга хэмжээ зохион байгуулах дүн	2023 онд гэрээ байгуулах болон худалдан авах ажиллагааг зохион байгуулах эсэх	Сая.төг	
													2023 онд гэрээ байгуулах болон худалдан авах ажиллагааг зохион байгуулах	
1	IX.1.131	Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээ (Хэнтий, Баян-Адарга, Баян-Овоо, Баянхутаг, Дадал, Дэлгэрхаан, Мөрөн, Норовлин, Цэнхэрмандал сум, Батноров сум, Бэрх тосгон)	2022	2023	11,063.4	7,728.51	-	18,980.5	10,561.68	4,555.78	14,235.75	14,235.75	ТБОНӨХБАУХА Тухай хуулийн 40.6 дугаар заалтын дагуу гэрээ байгуулах	
		<b>Дүн</b>			<b>11,063.4</b>	<b>7,917.10</b>	<b>-</b>	<b>18,980.50</b>	<b>10,561.68</b>	<b>4,555.78</b>	<b>14,424.34</b>	<b>14,424.34</b>	Худалдан авах ажиллагааг зохион байгуулах	